БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: БНА-2023/1/НА-СТА-ТЕЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2023 оны 04 дүгээр сарын 20


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn
Аудитор: Ж.Өсөхбаяр
Утас: 99890393 Цахим хаяг: Usukhbayarj@audit.gov.mn
Аудитор: Н.Бүнчинсүрэн
Утас: 99049866 Цахим хаяг: Bunchinsurenn@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН ....3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан....6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ....9
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт....9
3.5.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө....9
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт....12
3.5.3 Авлага ....12
3.5.4 Урьдчилгаа ....13
3.5.5 Бараа материал ....14
3.5.6 Үндсэн хөрөнгө....15
3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт....17
3.5.8 Өр төлбөр ....17
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо ....19
ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт....19
3.5.10. Нэмэлт санхүүжилтийн данс....20
4. АУДИТЫН ТАЙЛАН ....21
4.1. Ерөнхий зүйл ....21
4.2 Материаллаг байдал ....21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....21
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт: ....22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....23
4.4.1 Шилэн дансны мэдээлэл....23
4.5 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....24
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....27
4.7.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ....27
4.8 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал....29
5. Аудитын илрүүлэлт....30
5.1 Албан шаардлага....30
5.2. Зөвлөмж....31
5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....33

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АОУС, | Аудитын олон улсын стандарт |
| АДБОУС, | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ААНБ | Аж ахуй нэгж байгууллага |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НББОУС, | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| СТОУС, | Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт |
| СХАА, | Санхүүгийн хяналт аудитын алба |
| СТХС | Санхүү Төрийн сангийн хэлтэс |
| СХСан | Сум хөгжүүлэх сан |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ОНӨААН | Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ТӨААН | Төрийн өмчит аж ахуйн нэгж |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэрлэл |
| ЦТ | Цахилгаан түгээх |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХК | Хувьцаат компани |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төргүүлэгчдийн хурал |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсандданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023. 04.26 № 2/137.

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2022.03.30-ны өдрийн 131 дугаар тогтоол, Сангийн яамны 2023.01.05-ны өдрийн 10/84 дугаар “Аймгийн Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах” чиглэл, 2022 онд боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд харьяа яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгдэх болсонтой холбоотойгоор тайлант онд 116 байгууллагын 7,774.1 сая төгрөгийн бараа материал, 146,542.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий үндсэн хөрөнгө, нийт 154,316.6 сая төгрөгийн хөрөнгийг харьяа яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.1-д зааснаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын 40 хувийн аймгийн төсөвт оруулсантай холбогдуулан Сангийн яамнаас 2023 оны аймгийн ААНОАТ-ын орлогоос 448.3 сая төгрөгийг авч урьдчилж орсон орлогоор бүртгэсэн.

005020516
D/2023-A4 Alban toot

Тайланд онд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 548.8 сая төгрөгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний зээл, хүүгийн төлбөрт суутган тооцсон.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Баянхонгор аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 159 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээний үнэлгээний хэлтэс хяналтыг хэрэгжүүлж үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot

# 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 43,838,459.2 | 39,328,004.7 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 17,802,382.5 | 16,694,057.5 |
| **33** | **АВЛАГА** | 10,641,444.7 | 9,536,539.5 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 276,916.8 | 382,472.9 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 11,013,463.2 | 4,345,421.3 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 4,104,252.0 | 8,369,513.5 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 246,947,259.5 | 115,467,245.7 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 246,947,259.5 | 115,467,245.7 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 229,326,237.8 | 104,250,534.7 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 17,621,021.7 | 11,216,711.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 290,785,718.7 | 154,795,250.4 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 14,988,028.0 | 13,037,286.3 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 7,418,699.5 | 5,968,578.8 |
| **41300** | **Өглөг** | 7,284,674.6 | 5,367,118.6 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | 134,025.0 | 601,460.2 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 7,569,328.5 | 7,068,707.5 |
| **42200** | **Урт хугацаат зээл** | 7,569,328.5 | 7,068,707.5 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 275,797,690.7 | 141,757,964.1 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 275,797,690.7 | 141,757,964.1 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 95,482,032.0 | 52,363,723.6 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 119,059,912.0 | 71,921,315.2 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 61,255,746.7 | 17,472,925.3 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 290,785,718.7 | 154,795,250.4 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 192,176,314.3 | 119,313,925.2 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 15,266,944.4 | 21,144,728.9 |
| 110 | Орлогын албан татвар | 10,064,284.9 | 11,809,360.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 10,519,199.1 | 12,258,857.8 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (454,914.2) | (593,169.7) |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | - | 143,672.5 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 1,085,868.1 | 2,135,861.5 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 4,116,791.4 | 7,199,507.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 136,280,734.9 | 71,323,026.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 62,186,056.1 | 43,459,458.4 |
| 121 | Хөрөнгийн орлого | - | 72,282.9 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 74,094,678.8 | 27,791,284.6 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 40,628,635.0 | 26,846,170.3 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 154,978,953.9 | 96,000,399.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 154,978,953.9 | 96,000,399.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 148,407,470.6 | 80,479,777.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 46,523,356.9 | 9,958,153.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,102,546.8 | 1,245,316.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,061,153.1 | 1,258,363.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,961,241.2 | 2,540,184.8 |
| 2105 | Нормативт зардал | 3,386,053.9 | 212,856.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 866,073.4 | 324,349.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 249,994.1 | 161,413.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 44,573,631.6 | 39,127,209.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,683,419.6 | 25,651,931.2 |
| **212** | **ТАТААС** | 835,994.8 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,735,488.5 | 15,520,621.8 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 37,197,360.5 | 23,313,526.2 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,279,383.5 | 155,495,470.4 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 35,917,977.0 | (132,181,944.3) |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 154,719,725.5 | 98,718,514.7 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 15,206,923.8 | 21,593,056.4 |
| 110 | Орлогын албан татвар | 9,706,866.7 | 11,933,694.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 10,161,780.8 | 11,934,864.1 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (454,914.2) | (593,169.7) |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | - | 592,000.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 1,085,868.1 | 2,136,903.1 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 4,414,189.1 | 7,522,459.0 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 1,308,917.1 | 1,606,452.1 |
| 1181 | Газрын төлбөр | 1,162,161.1 | 696,170.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 1,916,808.4 | 5,078,545.1 |
| 1183 | Бусад татвар | 26,302.5 | 141,291.4 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 103,689,779.0 | 50,219,853.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 29,535,079.6 | 22,356,285.8 |
| 121 | Хөрөнгийн орлого | 60,020.6 | 72,282.9 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 74,094,678.8 | 27,791,284.6 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 35,823,022.6 | 26,905,604.9 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 110,665,011.3 | 61,499,934.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 110,665,011.3 | 61,499,934.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 102,630,246.2 | 58,276,430.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 46,900,520.3 | 11,840,982.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,115,270.9 | 1,457,717.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,068,984.6 | 11,000,224.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,139,082.3 | 1,977,859.2 |
| 2105 | Нормативт зардал | 2,157,074.5 | 227,834.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 991,051.5 | 497,726.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 241,186.6 | 163,582.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,006,580.5 | 11,235,175.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,010,495.1 | 19,875,327.4 |
| 212 | ТАТААС | 2,266,919.4 | 26,504.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,767,845.7 | 3,196,999.1 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 44,054,714.2 | 37,218,580.6 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 35,771,542.0 | 37,778,064.7 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 35,771,542.0 | 37,778,064.7 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 35,771,542.0 | 37,778,064.7 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (35,771,542.0) | (37,778,064.7) |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | - | (548,840.9) |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | - | 548,840.9 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 8,283,172.2 | (1,108,325.1) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 9,519,210.4 | 17,802,382.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 17,802,382.5 | 16,694,057.5 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 235,633,904.4 | 235,633,904.4 |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | 4,350,487.5 | 4,350,487.5 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 239,984,391.9 | 239,984,391.9 |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | (1,057,841.2) | (1,057,841.2) |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | 953,162.9 | 953,162.9 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 35,917,977.0 | 35,917,977.0 |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 275,797,690.7 | 275,797,690.7 |
| **11** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 275,797,690.7 | 275,797,690.7 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (4,134,994.0) | (4,134,994.0) |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 271,662,696.7 | 271,662,696.7 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (29,294.3) | (29,294.3) |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,135,629.5 | 1,135,629.5 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | (132,181,944.3) | (132,181,944.3) |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 141,757,964.1 | 141,757,964.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

( мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **58,993,192.6** | **51,608,731.5** | **7,384,461.1** | **87.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **43,602,011.7** | **39,544,498.4** | **4,057,513.3** | **90.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **40,866,830.7** | **36,911,371.7** | **3,955,459.0** | **90.3** |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 12,078,083.5 | 11,604,597.3 | 473,486.2 | 96.1 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,542,415.9 | 1,432,079.9 | 110,336.0 | 92.8 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,587,137.1 | 10,978,723.2 | 608,413.9 | 94.7 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 2,711,604.4 | 1,955,797.9 | 755,806.5 | 72.1 |
| **2105** | Нормативт зардал | 96,276.7 | 94,697.0 | 1,579.7 | 98.4 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 726,464.8 | 707,995.9 | 18,468.9 | 97.5 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 180,277.7 | 163,582.5 | 16,695.2 | 90.7 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,668,107.3 | 1,568,884.1 | 99,223.2 | 94.1 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,276,463.3 | 8,405,013.8 | 1,871,449.5 | 81.8 |
| **212** | **ТАТААС** | **32,000.0** | **26,504.3** | **5,495.7** | **82.8** |
| **2122** | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 32,000.0 | 26,504.3 | 5,495.7 | 82.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,703,181.0** | **2,606,622.5** | **96,558.5** | **96.4** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 1,575,900.0 | 1,548,396.8 | 27,503.2 | 98.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,127,281.0 | 1,058,225.7 | 69,055.3 | 93.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **15,074,505.9** | **11,515,392.1** | **3,559,113.8** | **76.4** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **316,675.0** | **548,840.9** | **(232,165.9)** | **173.3** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **58,993,192.6** | **51,537,683.0** | **7,455,509.6** | **87.4** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **51,613,292.5** | **49,761,168.5** | **1,852,124.0** | **96.4** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **7,379,900.1** | **1,776,514.5** | **5,603,385.6** | **24.1** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 4,218,927.6 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 4,147,879.1 | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1,645.00** | **1,529.00** | **116.00** | **92.9** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **798** | **740** | **58** | **92.7** |
| 620001 | Удирдах ажилтан | 204 | 185 | 19 | 90.7 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 375 | 353 | 22 | 94.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 156 | 150 | 6 | 96.2 |
| 620004 | Гэрээт ажилтан | 63 | 52 | 11 | 82.5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **9,588,633.4** | **2,612,006.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,573,052.4** | **2,601,919.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,860,662.2** | **2,263,786.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **20,672.5** | **-** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **294.2** | **1,468.3** |
| **2105** | **Нормативт зардал** | **1,250.0** | **-** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,500.0** | **9,997.9** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,746,752.1** | **2,252,320.3** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **89,193.4** | **-** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,712,390.2** | **338,133.1** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,216,880.2** | **120,000.0** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **495,510.0** | **218,133.1** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **15,581.0** | **10,086.5** |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **9,588,633.4** | **2,612,006.1** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **9,588,633.4** | **2,612,006.1** |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **(0.0)** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Баянхонгор аймаг нь “Авилаггүй шударга  төр, Архигүй айл өрх, Ажил орлоготой иргэн” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- УИХ-аас 2022 оны 04 сарын 29 өдөр “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг баталж мөрдүүлсэн.
- Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн найруулсан
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн найруулсан
- УИХ-аас 2022 онд “Төсвийн тухай” хуульд 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан
- Татварын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт орсон
- Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоол
- Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг
- төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоол
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 тоот тушаалаар баталсан
- Дундаж цалин хөлс тодорхойлох журам /2022 оноос мөрдөж эхэлсэн/
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 тоот тушаалаар баталсан.
- "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам /2022 оноос мөрдөж
- эхэлсэн/
- Бусад хууль, тогтоол, журам заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор-3, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор-2, дотоод аудитор-2, гэрээт ажилтан-2, хүний нөөц, архив, бичиг хэрэг, нягтлан бодогч, дотоод ажилтан-1 нийт-11 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан  байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээний үндсэн дээр бусад хэлтэс, агентлагийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:Санхүүгийн хяналт, дотоод аудитын  алба  нь 2022 оны байдлаар төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт-22, дотоод аудит-24, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 3 нийт 46  аудитыг хийж 92 заалт бүхий 36 зөвлөмж хүргүүлэн, улсын ахлах байцаагчийн 94.9 сая  төгрөгийн  төлбөрийн актын тогтоож, төлбөрийн актын барагдуулалт 90.2 хувьтай байна.

Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороо нь  аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, аймгийн Цагдаагийн газрын дарга, Мэргэжлийн төлөөлөл-2, Иргэдийн төлөөлөл-2, нарийн бичгийн дарга гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй бөгөөд 2022 онд 3 удаа хуралдаж 22 байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын тайланг хэлэлцэж, баталгаажуулж, 72 албан тушаалтанд

сахилгын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн саналыг хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан байна.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

## 3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

## 3.5. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 154,795.3 сая төгрөг болж өмнөх оноос 46.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр/өмч* */сая төгрөг/*

| Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү | Дүнд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 43,838.5 | 39,328.0 | (4,510.5) | 15.1 | 25.4 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 246,947.3 | 115,467.2 | (131,480.0) | 84.9 | 74.6 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **290,785.7** | **154,795.3** | **(135,990.5)** | **100.0** | **100.0** |
| Нийт өр төлбөр | 14,988.0 | 13,037.3 | (1,950.7) | 5.2 | 8.4 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 275,797.7 | 141,758.0 | (134,039.7) | 94.8 | 91.6 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **290,785.7** | **154,795.3** | **(135,990.5)** | **100.0** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 17,802.4 сая, эцсийн үлдэгдэл 16,694.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,108.3 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 15,990.7 сая буюу 95.8 хувь нь касс болон төрийн сангийн харилцах дансанд, 703.3 сая буюу 4.2 хувь нь арилжааны банканд байршиж байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Кассад байгаа бэлэн мөнгө | *Банканд байгаа бэлэн мөнгө* | | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Арилжааны банк | Төрийн сангийн нэгдсэн данс | |
| Кассад байгаа бэлэн мөнгө | 3.2 | 2.4 | 2.4 | - | - | (0.8) |
| Төгрөг/ ЖМС | 3.2 | 2.4 | 2.4 | | | (0.8) |
| Нэмэлт санхүүжилтийн | - | - | | | | - |
| Касс | - | - | | | | - |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 17,799.2 | 16,691.7 | - | 703.3 | 15,988.4 | (1,107.5) |
| Төгрөг | 17,799.2 | 16,691.7 | | 703.3 | 15,988.4 | (1,107.5) |
| Гадаад валют | - | - | | | | - |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | - | - | | | | - |
| **Нийт мөнгөн хөрөнгийн дүн** | **17,802.4** | **16,694.1** | **2.4** | **703.3** | **15,988.4** | **(1,108.3)** |
| *Үүнээс байгууллагын төрлөөр:* | | | | | | - |
| Төрийн сан | 5,395.6 | 7,121.2 | | - | 7,121.2 | 1,725.6 |
| Төсөвт байгууллагууд /ОНХС, СХС, Замын сан/ | 4,218.9 | 4,147.9 | | 1.2 | 4,146.7 | (71.0) |
| ОН-ын өмчит үйлдвэрийн газар | 933.9 | 704.5 | 2.4 | 702.2 | - | (229.4) |
| Төсөл, сангууд | 7,253.9 | 4,720.4 | | - | 4,720.4 | (2,533.5) |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө оны эхэнд 5,395.6 сая төгрөг байснаас оны эцэст 7,121.2 сая төгрөг болж өмнөх оноос 1,725.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь орон нутгийн давсан орлогын зарцуулагдаагүй 4,965.5 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн 1,456.7 сая, урьд оны харилцах дансны 699.0 сая төгрөгийг зарцуулаагүйгээс нийт 7,121.2 сая төгрөг байна.

*Хүснэгт 3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Сумын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Үүнээс | | | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Орон нутгийн давсан орлого | Буцаан төвлөрүүлэлт | Урьд оны зарцуулаагүй үлдэгдэл | |
| Галуут | 158.9 | 273.5 | 185.2 | 63.2 | 25.1 | 114.6 |
| Баян-овоо | 10.1 | 214.9 | 159.8 | 45.1 | 10.1 | 204.9 |
| Эрдэнэцогт | 201.6 | 380.0 | 185.2 | 50.0 | 144.7 | 178.4 |
| Бууцагаан | 57.5 | 197.0 | 138.1 | 15.3 | 43.6 | 139.5 |
| Жинст | 22.2 | 47.0 | 15.9 | 16.8 | 14.3 | 24.8 |
| Богд | 91.0 | 147.4 | 92.1 | 53.0 | 2.3 | 56.3 |
| Баянлиг | 72.6 | 68.7 | 15.3 | 53.5 | 0.0 | (3.8) |
| Баянговь | 41.8 | 72.2 | 48.3 | 14.6 | 9.3 | 30.4 |
| Гурванбулаг | 216.9 | 424.6 | 282.1 | 117.9 | 24.6 | 207.7 |
| Жаргалант | 189.0 | 210.3 | 168.9 | 41.4 | | 21.3 |
| Заг | 293.8 | 682.7 | 562.4 | 62.3 | 58.0 | 388.8 |
| Баацагаан | 25.3 | 236.9 | 146.6 | 90.3 | | 211.6 |
| Бөмбөгөр | 118.1 | 246.3 | 237.4 | 8.8 | | 128.2 |
| Өлзийт | 504.2 | 905.4 | 696.2 | 209.2 | 0.0 | 401.2 |
| Хүрээмарал | 90.7 | 130.2 | 18.5 | 98.2 | 13.5 | 39.5 |
| Баянбулаг | 57.0 | 180.0 | 137.7 | 32.9 | 9.5 | 123.1 |
| Шинэжинст | 116.5 | 109.3 | 28.7 | 65.0 | 15.6 | (7.2) |
| Баянцагаан | 54.7 | 447.7 | 397.9 | 47.2 | 2.7 | 393.1 |
| Баян-өндөр | 67.9 | 136.4 | 70.3 | 56.5 | 9.7 | 68.6 |
| Баянхонгор | 292.2 | 1,200.6 | 1,054.4 | 134.8 | 11.4 | 908.5 |
| **Сумын дүн** | **2,681.7** | **6,311.1** | **4,641.0** | **1,276.0** | **394.2** | **3,629.4** |
| Баянхонгор аймаг | 2,713.9 | 810.1 | 324.5 | 180.8 | 304.9 | (1,903.8) |
| **Нийт дүн** | **5,395.6** | **7,121.2** | **4,965.5** | **1,456.7** | **699.0** | **1,725.6** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант оны эцэст төсвийн ерөнхий орлогын данс 7,121.2 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 6,311.1 сая төгрөг нь 20 сумын орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бөгөөд оны эцэст аймгийн төвийн төсөвт байгууллагууд зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлснээс 180.8 сая, төлөвлөгөөнөөс давсан орлого болон урьд оны зарцуулаагүй үлдэгдэл 629.3 сая, нийт 810.1 сая төгрөг аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээр байна.

## Төсөвт байгууллага , сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,218.9 сая, эцсийн үлдэгдэл 4,147.9 сая төгрөг болж, өмнөх оноос 71.0 сая төгрөгөөр буурсан ба сум хөгжүүлэх сангийн 1,146.1 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 2,966.8 сая, замын сангийн 33.9 сая, өрхийн эмнэлгүүдийн арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл 1.2 сая төгрөг байна.

Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл өмнөх оноос 1,383.2 сая төгрөгөөс буурсан нь сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байгаа бол Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1,324.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь зарим сумд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

*Хүснэгт 4. Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Сумын нэр | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | Сумын нэр | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **СХСан** | **ОНХСан** | | **СХСан** | **ОНХСан** | **Замын сан** | **Өрхийн эмнэлгүүд** |
| Галуут | 39.9 | 182.2 | Баацагаан | 6.8 | 66.0 | - | - |
| Баян-Овоо | 13.9 | 98.0 | Бөмбөгөр | 20.1 | 308.9 | - | - |
| Эрдэнэцогт | 104.9 | 77.0 | Өлзийт | 40.4 | 16.0 | - | - |
| Бууцагаан | 47.9 | 76.9 | Хүрээмарал | 116.4 | 107.3 | - | - |
| Жинст | 0.1 | 26.8 | Баянбулаг | 29.9 | 71.9 | - | - |
| Богд | 26.2 | 15.6 | Шинэжинст | 38.2 | 486.2 | - | - |
| Баянлиг | 210.6 | 269.2 | Баянцагаан | 59.8 | 282.2 | - | - |

| Сумын нэр | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | Сумын нэр | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **СХСан** | **ОНХСан** | | **СХСан** | **ОНХСан** | **Замын сан** | **Өрхийн эмнэлгүүд** |
| Баянговь | 6.7 | 36.8 | Баян-Өндөр | 43.7 | 487.1 | - | - |
| Гурванбулаг | 102.7 | 91.9 | Баянхонгор сум | 101.4 | 104.4 | - | - |
| Жаргалант | 109.1 | 64.2 | Аймгийн ОНХС | - | 23.6 | - | - |
| Заг | 27.2 | 74.5 | Аймаг | - | - | 33.9 | 1.2 |
| **Нийт дүн** | | | | **1,146.1** | **2,966.8** | **33.9** | **1.2** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## Төсөл сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2,533.5 сая төгрөгөөр буурч, 4,720.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 4,115.7 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс тооцсон барьцаа, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн Барилгын тухай хуульд заасан баталгаат хугацааны баталгаа болон улсын төсвөөс хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний дутуу олгосон санхүүжилт байгаа бол 379.7 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс суутган тооцсон хяналтын зардал болон бусад зардлын зарцуулаагүй үлдэгдэл, орон нутгийн нөөц сангийн дансны үлдэгдэлд байгаа 225.0 сая төгрөг нь төсвийн байгууллагуудын нэмэлт дансны буцаан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл байна.

*Хүснэгт 5. Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн нөөц сан | 512.2 | 225.0 | (287.2) | 4.8 |
| Барьцаа хөрөнгийн данс | 6,212.2 | 4,115.7 | (2,096.5) | 87.2 |
| Техник хяналт данс | 529.5 | 379.7 | (149.8) | 8.0 |
| **Нийт дүн** | **7,253.9** | **4,720.4** | **(2,533.5)** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7[1]-т заасны дагуу ТШЗ-ийн 34 байгууллага нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл 225.0 сая төгрөгийг оны эцэст орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Дээрх үлдэгдлээс 5 байгууллагын 44.2 сая төгрөгийн үлдэгдлийг аймгийн Засаг даргын 2022.02.15-ны өдрийн А/88 дугаар захирамжаар төсөв захирагч нарт зарцуулах эрхийг нь нээж өгсөн, 162.7 сая төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэсэн байна.

## Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгө:

Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 935.1 сая, эцсийн үлдэгдэл 703.3 сая төгрөг болж, 231.8 сая төгрөгөөр буурсан бөгөөд үлдэгдлийн 99.8 хувийг ТӨҮГ болон ОНӨААН-ийн үлдэгдэл, 0.2 хувийг өрхийн эмнэлгүүдийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна.

*Хүснэгт 6. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Төсөвт байгууллага | 3.5 | 1.2 | (2.3) | 0.2 |
| Төсөл/ сан | 0.9 | - | (0.9) | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 930.8 | 702.2 | (228.6) | 99.8 |
| **Дүн** | **935.1** | **703.3** | **(231.8)** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

ТӨҮГ болон ОНӨҮГ-ийн харилцах дансны үлдэгдэл 702.2 сая төгрөг байгаагаас “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 49.2 сая, “Чандмань Баянхонгор” ХК-ийн үлдэгдэл 524.0 сая, “Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн үлдэгдэл 128.2 сая төгрөг байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Төсөвт байгууллагын арилжааны банкны үлдэгдэл 1.2 сая төгрөг байгаа нь аймгийн

[1] Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

төвийн 4 өрхийн эмнэлгийн харилцах дансны үлдэгдэл байна.

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 10,641.4 сая, эцсийн үлдэгдэл 9,536.5 сая төгрөг болж, 1,104.9 сая төгрөгөөр буурсан бөгөөд нийт авлагын 35.4 хувь буюу 3,376.7 сая төгрөгийг хувь хүмүүс болон байгууллагаас авах авлага, 64.2 хувь буюу 6,119.4 сая төгрөгийг сумдын хоршоо хөгжүүлэх сан, Үйлдвэржилт хөгжлийн корпорацын жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр олгосон зээлийн авлага байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 7. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

| Ангилал | Өмнөх он | Тайлант он | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон авлага | 94.4 | 13.6 | (80.8) | 0.1 |
| Төлбөрт үйлчилгээний авлага | 25.7 | 16.2 | (9.5) | 0.2 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 3,574.8 | - | (3,574.8) | - |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 54.4 | 10.6 | (43.8) | 0.1 |
| Бусад авлага | 2,332.2 | 3,376.7 | 1,044.5 | 35.4 |
| Зээлийн авлага | 4,559.9 | 6,119.4 | 1,559.5 | 64.2 |
| **Дүн** | ***10,641.4*** | ***9,536.5*** | ***(1,104.9)*** | ***100.0*** |
| Үүнээс байгууллагын төрлөөр: | | | **-** | **-** |
| Төсөвт байгууллага | 8,041.4 | 6,036.8 | (2,004.5) | 63.3 |
| Төсөл/сан | 130.8 | - | (130.8) | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 2,469.3 | 3,499.7 | 1,030.4 | 36.7 |
| **Нийт дүн** | ***10,641.4*** | ***9,536.5*** | ***(1,104.9)*** | ***100.0*** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь авлагын дансны бүртгэлийг тооцоо нийлсэн акт, насжилтаар ангилж харуулбал нийт авлагын 94.3 хувь буюу 8,995.8 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, нийт авлагын 92.6 хувь буюу 8,835.4 сая төгрөгийн үлдэгдэл нь 5-аас дээш жилийн насжилттай, мөн нийт авлагын 0.9 хувь буюу 90.1 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн гэсэн ангиллаар нэгтгэгдсэн байна.

*Хүснэгт 8. Авлагын үлдэгдэл насжилтаар* *(/сая төгрөг/)*

| Ангилал | Ажилчидтай холбогдсон авлага | Төлбөрт үйлчилгээний авлага | Дансны авлага /ТӨҮГ/ | Байгууллагаас авах авлага | Хувь хүмүүсээс авах авлага | Зээлийн авлага | Нийт | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тооцоо нийлсэн | - | 7.0 | - | 31.5 | 131.9 | 370.3 | 540.7 | 5.7 |
| Тооцоо нийлсэн акт байхгүй | 13.6 | 9.2 | 10.6 | 2,834.7 | 378.6 | 5,749.2 | 8,995.8 | 94.3 |
| **Дүн** | **13.6** | **16.2** | **10.6** | **2,866.2** | **510.5** | **6,119.4** | **9,536.5** | **100.0** |
| Үүнээс авлагын насжилтаар: | | | | | | | | |
| Эц.Үлд 0-1 жил | 1.0 | 7.0 | - | 147.9 | 3.9 | 212.9 | 372.8 | 3.9 |
| Эц.Үлд 1-2 жил | - | - | - | 0.6 | 10.0 | 93.9 | 104.5 | 1.1 |
| Эц.Үлд 2-3 жил | - | - | - | - | - | 197.3 | 197.3 | 2.1 |
| Эц.Үлд 3-4 жил | - | - | - | - | - | 15.4 | 15.4 | 0.2 |
| Эц.Үлд 4-5 жил | - | - | - | 5.6 | - | 5.5 | 11.1 | 0.1 |
| Эц.Үлд 5-аас дээш жил | 12.6 | 9.2 | 10.6 | 2,712.0 | 496.6 | 5,594.4 | 8,835.4 | 92.6 |
| **Нийт дүн** | **13.6** | **16.2** | **10.6** | **2,866.2** | **510.5** | **6,119.4** | **9,536.5** | **100.0** |
| Үүнээс хугацаа хэтэрсэн ангиллаар бүртгэсэн: | | | | | | | | |
| 0-1 жил | - | 7.0 | - | - | - | 15.4 | 22.4 | 24.8 |
| 1-2 жил | - | - | - | - | - | 26.6 | 26.6 | 29.6 |
| 3-4 жил | - | - | - | - | - | 12.8 | 12.8 | 14.2 |
| 4-5 жил | 0 | - | 0 | 0 | - | 1.7 | 1.7 | 1.9 |
| 5-аас дээш жил | 0 | - | 0 | 0 | 2.0 | 24.6 | 26.6 | 29.5 |
| **Нийт дүн** | | **7.0** | | | **2.0** | **81.1** | **90.1** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх бүртгэлээс харахад Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллагууд нь авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байхад тооцоо нийлсэн актгүйгээр бүртгэсэн, мөн тайлант онд үүссэн болон 5-аас бага жилийн насжилттай авлагын насжилтыг буруу бүртгэсэн мөн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг дутуу бүртгэсэн зэргээр нягтлан бодогч нар э-тайланд авлагын тодруулгыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байхад түүнд хяналт тавиагүй байна.

Иймд Сангийн яамны Э-тайланд авлагын тодруулга тайланг буруу бүртгэсэн зөрчлийг арилгаж цаашид үнэн зөв бүртгэж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 6,119.4 сая төгрөг зээлийн авлага байгаа бөгөөд үүний 32.4 хувь нь буюу 1,983.6 сая төгрөг нь "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК буюу жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгож буй хөнгөлөлттэй зээлийн авлага, 66.9 хувь буюу 4,094.5 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 0.7 хувь буюу 41.3 сая төгрөг нь Баян-Өндөр сумын ОНХС-аас олгосон малжуулах төслийн 37.0 сая, Шинэжинст сумын ЗДТГ-ын малчдад зээлээр олгосон өвсний 4.3 сая төгрөгийн авлага байна.

*Хүснэгт 9. Зээлийн авлага /сая төгрөг/*

| Байгууллагын төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) |
|---|---|---|---|
| Сум хөгжүүлэх сан | 2,630.5 | 4,094.5 | 1,422.7 |
| "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК | 1,888.1 | 1,983.6 | 95.5 |
| Бусад төсөвт байгууллага | 41.3 | 41.3 | 41.3 |
| **Дүн** | **4,559.9** | **6,119.4** | **1,559.5** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага 2022 оны эхний үлдэгдэл 2,630.5 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 4,094.5 сая төгрөг болж 1,422.7 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд нийт 2,356.2 сая төгрөгийн зээл олгож, 998.1 сая төгрөгийн зээлийн төлбөрийг төлүүлсэнтэй холбоотой ба энэ хэмжээгээр СХС-гийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,146.1 сая төгрөгт болж өмнөх оноос 1,383.2 сая төгрөгөөр буурсан байна.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл нь Баянхонгор сум хамгийн өндөр буюу 960.8 сая, Баянлиг сум хамгийн бага буюу 45.3 сая төгрөгийн авлагатай байна.

*Хүснэгт 10. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага сумдаар /сая төгрөг/*

| № | Сумын нэр | Хувь хүмүүст олгосон зээлийн авлага | | № | Сумын нэр | Хувь хүмүүст олгосон зээлийн авлага | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөх он | Тайлант он | | | Өмнөх он | Тайлант он |
| 1 | Баянбулаг | 119.5 | 185.6 | 11 | Баян-Өндөр | 112.3 | 157.5 |
| 2 | Баянговь | 48.2 | 204.5 | 12 | Галуут | 119.7 | 231.2 |
| 3 | Богд | 102.3 | 184.3 | 13 | Гурванбулаг | 144.8 | 101.3 |
| 4 | Баянлиг | 69.4 | 45.3 | 14 | Жаргалант | 197.8 | 149.7 |
| 5 | Баян-Овоо | 79.2 | 158.1 | 15 | Жинст | 123.8 | 193.4 |
| 6 | Бөмбөгөр | 105.0 | 166.7 | 16 | Заг | 107.9 | 166.8 |
| 7 | Бууцагаан | 134.9 | 190.1 | 17 | Хүрээмарал | 132.6 | 87.9 |
| 8 | Баянхонгор | 325.4 | 960.8 | 18 | Шинэжинст | 107.5 | 168.4 |
| 9 | Баацагаан | 155.6 | 249.1 | 19 | Эрдэнэцогт | 114.1 | 80.2 |
| 10 | Баянцагаан | 140.7 | 204.8 | 20 | Өлзийт | 189.8 | 208.7 |
| | **НИЙТ ДҮН** | | | | | **2,630.5** | **4,094.5** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 276.9 сая, эцсийн үлдэгдэл 382.5 сая төгрөг болж, өмнөх оноос 105.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 12. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | | 255.5 | 255.5 | 66.8 |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 275.2 | 126.7 | (148.5) | 33.1 |
| Цалингийн урьдчилгаа | 1.7 | 0.3 | (1.5) | 0.1 |
| **Дүн** | **186.4** | **382.5** | **105.6** | **100.0** |
| Үүнээс, байгууллагын төрлөөр | | | | |
| Төсөвт байгууллага | 1.7 | 0.3 | (1.5) | 0.1 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 275.2 | 382.2 | 107.0 | 99.9 |
| **Дүн** | **276.9** | **382.5** | **105.6** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансанд бүртгэгдсэн 382.5 сая төгрөгийн үлдэгдлээс 126.7 сая төгрөг нь “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой 2022 онд төлөвлөгдсөн дутуу хийж гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын урьдчилж гарсан зардал, “Чандмань-Баянхонгор” ХК-ийн лабораторийн барилгын урьдчилж гарсан зардал 215.8 сая, мөн “Баян өсөх агро” ОНӨАТҮГ-ын 2022 оны үйл ажиллагааны зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Харин цалингийн урьдчилгааны 0.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэл нь Баянговь сумын ЗДТГ-ын цалингийн урьдчилгааны авлага байна.

**Аудитын илрүүлэлт:**

***Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангаас олгосон зураг төсвийн 789.4 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд техник хяналтын барьцаа дансны авлагын үлдэгдлээр давхардуулан бүртгэсэн байсныг аудитын явцад залруулж бүртгүүлэв.***

### 3.5.5 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 11,013.5 сая төгрөг байсан ба оны эцэст үлдэгдэл 4,345.4 сая төгрөг болж, 60.5 хувиар буюу 6,668.0 сая төгрөгөөр буурсан, нөөцийн барааны эхний үлдэгдэл 4,104.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,369.5 сая төгрөг болж 4,265.3 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 13. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

| Бараа материалын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 2,045.2 | 317.0 | (1,728.2) | 2.5 |
| Эм боох материал | 537.6 | 5.3 | (532.3) | 0.0 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 382.0 | 540.8 | 158.8 | 4.3 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 90.7 | 99.8 | 9.1 | 0.8 |
| Бичиг хэргийн материал | 245.8 | 87.6 | (158.2) | 0.7 |
| Аж ахуйн материал | 3,564.3 | 1,317.6 | (2,246.7) | 10.4 |
| Сэлбэг хэрэгсэл | 61.6 | 70.6 | 9.0 | 0.6 |
| Түлш, шатах тослох материал | 44.6 | 3.7 | (40.8) | 0.0 |
| Барилгын засварын материал | 162.7 | 13.7 | (149.0) | 0.1 |
| Хүнсний материал | 89.6 | 1.4 | (88.2) | 0.0 |
| Бусад хангамжийн материал | 3,598.2 | 1,731.5 | (1,866.7) | 13.6 |
| Мал амьтад | 191.3 | 156.5 | (34.7) | 1.2 |
| **Бараа материалын дүн** | **11,013.5** | **4,345.4** | **(6,668.0)** | **34.2** |
| Нөөцийн бараа | 4,104.3 | 8,369.5 | 4,265.3 | 65.8 |
| **НИЙТ ДҮН** | **15,117.7** | **12,714.9** | **(2,402.8)** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант оны эцэст төсөвт байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 6,668.0 сая төгрөгөөр буурсанд тусгай зориулалтын материал 1,728.2 сая, эм боох материал 532.3 сая, бичиг хэргийн материал 158.2 сая, аж ахуйн материал 2,246.7 сая, бусад хангамжийн материал 1,866.7 сая төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Харин нөөцийн бараа дансны үлдэгдэл 4,265.3 сая төгрөгөөр нэмэгдсэнд аймаг сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн дуусаагүй ажлын 2,696.3 сая, аймгийн ангилагдаагүй зардлаар санхүүжсэн 1,184.3 сая төгрөгийн дуусаагүй ажил, Баян-Овоо, Баянхонгор, Заг, Шинэжинст, Өлзийт, Жаргалант сумдын ЗДТГ-ын хөрөнгөөр санхүүжсэн дуусаагүй ажлын 275.4 сая төгрөгийг тайлант онд бүртгэсэн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 95.1 хувийг төсөвт байгууллага, 4.9 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

*Хүснэгт 14. Бараа материалын хөдлөл өөрчлөлт /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| ***Эхний үлдэгдэл*** | 13,422.3 | 15,117.7 | 1,695.4 |
| *Нэмэгдсэн* | 15,964.3 | 9,798.9 | (6,165.3) |
| Худалдан авсан | 13,245.8 | 8,518.6 | (4,727.3) |
| Хандиваар | 669.4 | 368.6 | (300.8) |
| Шилжүүлэн авсан | 859.4 | 378.8 | (480.6) |
| Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр | 153.4 | - | (153.4) |
| Бусад | 1,036.2 | 532.9 | (503.3) |
| *Хасагдсан* | 14,268.8 | 12,201.7 | (2,067.1) |
| Худалдсан, зарцуулсан | 13,027.2 | 4,009.6 | (9,017.6) |
| Шилжүүлсэн | 459.1 | 233.3 | (225.8) |
| Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр | 18.7 | 7,774.1 | 7,755.4 |
| Бусад /Акталсан/ | 763.8 | 184.6 | (579.1) |
| ***Эцсийн үлдэгдэл*** | **15,117.7** | **12,714.9** | **(2,402.8)** |
| ***Үүнээс, байгууллагын төрлөөр*** | | | - |
| Төсөвт байгууллага | 14,640.1 | 12,091.2 | (2,548.9) |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 477.6 | 623.7 | 146.1 |
| **Дүн** | **15,117.7** | **12,714.9** | **(2,402.8)** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8,518.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 368.6 сая, балансаас баланст 911.8 сая төгрөгийн материал шилжүүлэн авч, нийт 9,798.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 4,009.6 сая төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 8,007.5 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланст шилжүүлж, 184.6 сая төгрөгийн бараа материалыг акталж нийт 14,268.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үүнээс 2022 оны төсвийн шинэчлэлтэй холбоотой 7,655.1 сая төгрөгийн бараа материал, 119.0 сая төгрөгийн нөөцийн бараа нийт 7,774.1 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр аймгийн ТЕЗ-ийн тайлангаас харьяа яамдын орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө дансанд шилжүүлсэн байна.

*Хүснэгт 13. Бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал /сая төгрөг/*

| Бараа материалын нэр | Бараа материал | Нөөцийн бараа | Нийт |
|---|---|---|---|
| Боловсролын байгууллагууд | 5,507.8 | 119.0 | 5,626.8 |
| БТСГ | 35.1 | - | 35.1 |
| ГХБХБГ | 32.6 | - | 32.6 |
| Музей | 20.9 | - | 20.9 |
| Номын сан | 8.7 | - | 8.7 |
| Өрхийн эмнэлэг | 61.8 | - | 61.8 |
| Соёлын төвүүд | 284.0 | - | 284.0 |
| Тэмүүжин театр | 87.7 | - | 87.7 |
| ХГБЗХГ | 103.9 | - | 103.9 |
| ХДТеатр | 298.2 | - | 298.2 |
| Эрүүл мэндийн төвүүд | 1,214.4 | - | 1,214.4 |
| **Нийт дүн** | **7,655.1** | **119.0** | **7,774.1** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

**Аудитын илрүүлэлт:**

*Тайлант онд нийт төсвийн шинэчлэлтэй холбоотой 7,774.1 сая төгрөгийн бараа материалыг орон нутгийн өмчөөс харьяа яамдын санхүүгийн тайланд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн бүртгэхдээ Өлзийт сумын эцэрлэг, Заг сумын ЭМТ-ийн бараа материалын үлдэгдлийг 90.5 сая төгрөгөөр үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй гарсан зардлаар дутуу бүртгэсэн байсныг аудитын явцад залруулж бүртгүүлэв.*

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 318,855.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 168,011.0 сая төгрөг болж 150,844.4 сая төгрөгөөр буурсан бөгөөд үүнээс төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө 153,703.6 сая төгрөгөөр буурсан нь голлох нөлөө үзүүлж байна.

Нийт үндсэн хөрөнгийн 93.2 хувийг биет хөрөнгө, 6.8 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл 11,498.8 сая төгрөг болж өмнөх оноос 6,356.8

сая төгрөгөөр буурсан бөгөөд 1.6 хувийг программ хангамж, 98.4 хувийг газар буюу бусад биет бус хөрөнгө эзэлж байна.

*Хүснэгт 15. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Ангилал | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 230,726.3 | 102,009.0 | (128,717.3) | 60.7 |
| Тээврийн хэрэгсэл | 9,246.1 | 8,957.1 | (288.9) | 5.3 |
| Машин тоног төхөөрөмж | 26,317.2 | 13,766.1 | (12,551.1) | 8.2 |
| Тавилга эд хогшил | 10,229.2 | 3,381.5 | (6,847.8) | 2.0 |
| Зам гүүрний барилга байгууламж | 2,651.4 | 5,629.5 | 2,978.1 | 3.4 |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 968.0 | 7.8 | (960.2) | 0.0 |
| Дуусаагүй барилга байгууламж | 1,546.5 | 636.3 | (910.1) | 0.4 |
| Номын фонд | 1,050.0 | 46.0 | (1,004.0) | 0.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 18,180.6 | 22,078.8 | 3,898.2 | 13.1 |
| Программ хангамж | 273.9 | 189.4 | (84.5) | 0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 17,666.3 | 11,309.5 | (6,356.8) | 6.7 |
| **Дүн** | **318,855.5** | **168,011.0** | **(150,844.4)** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,928.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 13,284.2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансt, 100.9 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 1,164.6 сая төгрөгийг хандиваар авч, бусад эх үүсвэрээс 6,894.8 сая, дахин үнэлгээний 13.9 сая төгрөгийн нэмэгдэл бүртгэж нийт 23,386.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 174,230.9 сая төгрөгийн хөрөнгө хасагдсанаас 627.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 576.7 сая төгрөгийн хөрөнгийг актлан, бүтцийн өөрчлөлтөөр 173,015.1 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

*Хүснэгт 16. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Биет хөрөнгийн дүн | Биет бус хөрөнгийн дүн | Нийт хөрөнгийн дүн |
|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл | **300,915.3** | **17,940.2** | **318,855.5** |
| **Нэмэгдсэн** | 22,460.6 | 925.9 | 23,386.5 |
| Худалдан авсан | 1,872.3 | 55.8 | 1,928.1 |
| Хандиваар | 1,140.2 | 24.5 | 1,164.6 |
| Шилжүүлэн авсан | 13,214.7 | 69.4 | 13,284.2 |
| Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр | 100.9 | - | 100.9 |
| Бусад | 6,132.5 | 762.2 | 6,894.8 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | - | 13.9 | 13.9 |
| **Хасагдсан** | **166,863.7** | **7,367.2** | **174,230.9** |
| Худалдсан | - | - | - |
| Акталсан | 576.3 | 0.4 | 576.7 |
| Шилжүүлсэн | 626.9 | 0.3 | 627.2 |
| Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр | 165,648.6 | 7,366.5 | 173,015.1 |
| Бусад | 11.8 | 7,366.5 | 7,378.3 |
| Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **156,512.2** | **11,498.8** | **168,011.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Шилжүүлэн авсан гэсэн орлогын зүйлээр тайлант онд 13,284.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнд Чандмань - Баянхонгор” ХК-ийн хөрөнгөд Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн 909.1 сая төгрөгийн цэвэрлэх байгууламж, “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн хөрөнгөд 3,959.3 сая төгрөгийн автозам, Баянлиг сумын ЗДТГ-ын хөрөнгөд 1,392.1 сая төгрөгийн хуучийн соёлын төв, сургуулийн барилга, Өлзийт сумын ЗДТГ-ын хөрөнгөд улсын төсвийн хөрөнгөөр сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн 3,959.3 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээж авч бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн бусад хэсэгт нэмэгдсэн 6,894.8 сая төгрөг нь Галуут сумын ЗДТГ-ын хөрөнгөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,978.1 сая төгрөгийн гүүр, Гурванбулаг сумын ЗДТГ-ын хөрөнгөд уул уурхайн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,200.0 сая төгрөгийн Спорт заалны барилга, Шинэжинст сумын ЗДТГ-ын уул уурхайн хандиваар өгсөн 168.0 сая төгрөгийн худаг, БОАЖГ-ын хөрөнгөд 358.6 сая төгрөгийн газар, 177.0 сая

төгрөгийн виртуал музейн барилгыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн зэрэг нь нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Дуусаагүй барилга дансанд өмнөх онд 8 байгууллагын 1,546.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэйгээс тайлант онд "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ийн 615.4 сая төгрөгийн дуусаагүй барилга нэмэгдэж, 5 байгууллагын 208.8 сая төгрөгийн дуусаагүй барилгыг ашиглалтад хүлээн авч, 3 байгууллагын 1,316.8 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж, 5 байгууллагын 636.3 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй үйлдвэрлэл дансанд үлдэгдлээр байна.

Энэ нь "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ийн 615.4 сая төгрөгийн лабораторийн барилга, Баян-Овоо хуучин спорт заалны барилга 5.8 сая, Өлзийт сумд төсвийн хөрөнгөөр хийсэн 7.4 сая төгрөгийн тоглоом, Хүрээмарал сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн 7.4 сая төгрөгийн цэцэрлэгт хүрээлэн, Баянхонгор-Чандмань ХК-ийн 11.0 сая төгрөгийн зураг төсөв зэргийг дуусаагүй барилгад бүртгэсэнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Тайлант онд Шинэжинст, Гурванбулаг сумын ЗДТГ нийт 1,368.0 сая төгрөгийн хандивын хөрөнгө, Галуут сумын ЗДТГ 2,978.1 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг тус тус бусад гэсэн орлогын зүйлээр, Богд, Баянцагаан сумын ЗДТГ нь нийт 100.9 сая төгрөгийг ОНХС-аар бий болсон хөрөнгийг шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр гэсэн ангиллаар бүртгэсэн байсныг аудитын явцад залруулж бүртгүүлэв.*

### 3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 14,988.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13,037.3 сая төгрөг болж, 1,950.7 сая төгрөгөөр буурсан байна.

Үүнээс богино хугацаат өр төлбөр 5,968.6 сая төгрөг болж өмнөх оноос 1,450.1 сая төгрөгөөр буурсан ба нийт өр төлбөрийн 45.8 хувийг богино хугацаат өр төлбөр, 54.2 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

*Хүснэгт № 17. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Ангилал | Өмнөх он | Тайлант он | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| **Богино хугацаат өр төлбөр** | **7,418.7** | **5,968.6** | **(1,450.1)** | **45.8** |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 115.9 | 15.6 | (100.3) | 0.3 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 512.2 | 683.6 | 171.3 | 11.5 |
| Байгууллагад өгөх өглөг | 6,543.6 | 4,436.8 | (2,106.7) | 74.3 |
| Хувь хүмүүст өгөх өглөг | 6.5 | 0.8 | (5.7) | 0.0 |
| Татварын өглөг /ТӨҮГ/ | 87.9 | 225.7 | 137.7 | 3.8 |
| НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 0.1 | 2.3 | 2.2 | 0.0 |
| Дансны өглөг /ТӨҮГ/ | 18.5 | 2.4 | (16.1) | 0.0 |
| Урьдчилж олсон орлого | 134.0 | 601.5 | 467.4 | 10.1 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **7,569.3** | **7,068.7** | **(500.6)** | **54.2** |
| **Төгрөг** | **7,039.3** | **6,559.7** | **(479.7)** | **92.8** |
| Хувь хүмүүсийн зээл | 2,062.4 | 2,107.4 | 45.1 | |
| Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/ | 4,977.0 | 4,452.2 | (524.7) | |
| **Гадаад валют** | **530.0** | **509.0** | **(21.0)** | **7.2** |
| Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/ | 530.0 | 509.0 | (21.0) | |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **14,988.0** | **13,037.3** | **(1,950.7)** | **100.0** |
| **Үүнээс байгууллагын төрлөөр:** | | | | |
| **Богино хугацаат өр төлбөр дүн** | **7,418.7** | **5,968.6** | **(1,450.1)** | **45.8** |
| Төсөвт байгууллага | 843.2 | 373.1 | (470.1) | 6.3 |
| Төсөл/сан | 6,285.2 | 4,278.5 | (2,006.7) | 71.7 |
| Төрийн сан | | 448.3 | 448.3 | 7.5 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 290.3 | 868.7 | 578.4 | 14.6 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **7,569.3** | **7,068.7** | **(500.6)** | **54.2** |
| Төсөвт байгууллага | 4,818.2 | 4,335.0 | (483.2) | 61.3 |
| Төсөл/сан | - | - | - | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 2,751.1 | 2,733.7 | (17.4) | 38.7 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **14,988.0** | **13,037.3** | **(1,950.7)** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### Богино хугацаат өр төлбөр:

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 6.3 хувь буюу 373.1 сая төгрөгийн өглөг нь төсөвт байгууллагын, 71.7 хувь буюу 4,278.5 сая төгрөг нь техник хяналт, барьцаа данс, нэмэлт санхүүжилтийн өглөг, 14.6 хувь буюу 868.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын өр, 7.5 хувь буюу 448.3 сая төгрөг нь төрийн сангийн урьдчилж орсон орлого байна

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат үнэт цаас, богино хугацаат зээл байхгүй ба урьдчилж орсон орлого нь “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн төсөл хөтөлбөрт олгосон зээлээс суутгасан хяналтын зардал, түрээслэгчдээс урьдчилж авсан нэг сарын түрээсийн төлбөр 153.2 сая төгрөгийн урьдчилж орсон орлого мөн Сангийн яамнаас аж ахуйн нэгжийн албан татварын 2023 оны орлого 448.3 сая төгрөгийг урьдчилж олгосныг бүртгэсэн байна.

### Урт хугацаат өр төлбөр:

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл оны эхэнд 7,569.3 сая төгрөг байсан ба тайлант онд 540.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, 40.0 сая төгрөгийн өглөг нэмэгдэж оны эцэст 7,068.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

*Хүснэгт 18. Урт хугацаат өр төлбөр /сая төгрөг/*

| Байгууллагын нэр | Зээлийн эх үүсвэр | Эхний үлдэгдэл | Нэмэгдсэн гүйлгээний дүн | Хорогдсон гүйлгээний дүн | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | 7,569.3 | 40.0 | 540.6 | 7,068.7 |
| **Урт хугацаат зээл** | | 7,569.3 | 40.0 | 540.6 | 7,068.7 |
| ***Төгрөг*** | | ***7,039.3*** | ***40.0*** | ***519.7*** | ***6,559.7*** |
| Чандмань Баянхонгор ХК | Чандмань Баянхонгор ХК Mon-1847 | 158.8 | | 36.4 | 122.3 |
| | Хас банкны зээл | - | | | - |
| Аймгийн ОНӨГ | Чандмань Баянхонгор ХК Mon-2301 | 4,818.2 | | 483.2 | 4,335.0 |
| Баян өсөх агро ОНӨААТҮГ | Санхүүжилтийн өглөг /хувийн хэвшил/ | | 40 | | 40.0 |
| "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК | Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/ | 1,557.4 | | | 1,557.4 |
| | Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/ | 429.5 | | | 429.5 |
| | Төрийн сан /Ангилагдаагүй зардал-жимс жимсгэнэ тариалах/ | 0.5 | | | 0.5 |
| | Төрийн сан /ЖДҮ-ийн эргэн төлөлт | 75.0 | | | 75.0 |
| **Гадаад валют** | | **530.0** | **0.0** | **21.0** | **509.0** |
| "Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК | "Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-Mon-1847 | 11.2 | - | 4.0 | 7.2 |
| | "Баянхонгор -Эрчим хүч"ЦТХХК-Mon-3500 | 518.8 | | 16.9 | 501.8 |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн 249.7 сая төгрөгөөр буурсан нь “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй МОН-1847 зээлээс 4.0 сая, Дэлхийн банкны санхүүжилтээр олгосон МОН-3500 зээлээс 16.9 сая төгрөгийг төлсөнтэй холбоотой байна.

Мөн нийт урт хугацаат зээлээс “Чандман-Баянхонгор” ХК-ийн МОН-1847 төслийн зээлээс 36.4 сая төгрөгийг барагдуулсан бол Сангийн яам аймгийн ОНӨГ-т бүртгэлтэй МОН-2301 төслийн зээлээс 483.2 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын шилжүүлгээс суутган тооцсон мөн шинээр үүсгэн байгуулагдсан “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын санхүүжилтийн 40.0 сая төгрөгийн өглөгийг урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн байна.

***Аудитын илрүүлэлт:***

*Тайлант онд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-ийн урьдчилж орсон орлогоор орсон 45.1 сая төгрөгийг э-тайланд нэгтгэхдээ урт хугацаат өр төлбөрийн үлдэглийг нэмэгдүүлж бүртгэсэн байсныг аудитын явцад залруулж бүртгэв.*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 275,797.7 сая, эцсийн үлдэгдэл 141,758.0 сая төгрөг болж, өмнөх оноос 134,039.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 20. Хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 95,482.0 | 52,363.7 | (43,118.3) | 36.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 61,255.7 | 71,921.3 | 10,665.6 | 50.7 |
| Хуримтлагдсан үр дүн | 119,059.9 | 17,472.9 | (101,587.0) | 12.3 |
| **Дүн** | **275,797.7** | **141,758.0** | **(134,039.7)** | **100.0** |
| **Үүнээс, байгууллагын төрлөөр** | | | | |
| Төсөвт байгууллага | 238,062.6 | 101,789.1 | (136,273.5) | 71.8 |
| Төсөл/ сан | 1,099.6 | 442.0 | (657.6) | 0.3 |
| Төрийн сан | 5,395.6 | 6,672.9 | 1,277.3 | 4.7 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 31,240.0 | 32,854.0 | 1,614.1 | 23.2 |
| **Дүн** | **275,797.7** | **141,758.0** | **(134,039.7)** | **100.0** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын оруулсан капитал данс нь үндсэн хөрөнгийн өсөлтийн 43,118.3 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 101,587.0 сая буурч, дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой 10,665.6 сая төгрөгөөр дахин үнэлгээний нөөц данс нэмэгдсэн байна.

Үүнд төсвийн шинэчлэлтэй холбоотой 116 байгууллагын 7,774.1 сая төгрөгийн бараа материал, 146,542.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр аймгийн ТЕЗ-ийн тайлангаас харьяа яамдын орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө дансанд шилжүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

*Хүснэгт 21. Орон нутгийн өмчөөс яамдад-шилжүүлсэн хөрөнгө /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Бараа материал | Үндсэн хөрөнгө | Нийт |
|---|---|---|---|
| Боловсролын салбарын байгууллагууд | 5,626.8 | 92,299.8 | 97,926.6 |
| Биеийн тамир спортын газар | 35.1 | 7,022.4 | 7,057.5 |
| Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | 32.6 | 567.8 | 600.4 |
| Музей | 20.9 | 1,690.2 | 1,711.2 |
| Номын сан | 8.7 | 2,166.3 | 2,175.0 |
| Өрхийн эмнэлгүүд | 61.8 | 1,045.3 | 1,107.1 |
| Сумдын соёлын төвүүд | 284.0 | 22,689.6 | 22,973.6 |
| Тэмүүжин театр | 87.7 | 35.9 | 123.7 |
| Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар | 103.9 | 366.1 | 470.1 |
| Хөгжимт драмын театр | 298.2 | 1,092.5 | 1,390.7 |
| Сумдын эрүүл мэндийн төвүүд | 1,214.4 | 17,566.5 | 18,780.9 |
| **Дүн** | **7,774.1** | **146,542.4** | **154,316.6** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бодлогын өөрчлөлт алдааны залруулгын данс дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгө шилжиж ирсэн мөн акталсан, үндсэн хөрөнгийг үлдэгдэл залруулсан, өмнөх оны үндсэн хөрөнгийн элэгдэл, өглөг, авлагыг зөрүүтэй тооцсон зэргээр 84,043.3 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн байна.

### ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт

Аймгийн Засаг даргын харьяаны орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 7 байгууллагын санхүүгийн тайланд хуримтлагдсан үр дүн -1,055.1 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

*Хүснэгт 21.ОНӨААН-ийн хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/*

| № | ААН нэр | тоо | Орлого | Зарлага | 2022 оны үр дүн | Өмнөх үеийн үр дүн | Хуримтлагдсан үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баянхонгор Эрчим хүч ХХК | 1 | 12,377.9 | 12,155.5 | 222.4 | (914.9) | (692.5) |
| 2 | Чандмань Баянхонгор ХК | 1 | 2,442.3 | 2,306.5 | 135.9 | 382.3 | 518.2 |
| 3 | Цэвэр хот ОНӨҮГазар | 1 | 1,199.9 | 846.1 | 353.7 | (369.1) | (15.4) |
| 4 | Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК | 1 | 121.9 | 454.2 | (332.3) | (700.0) | (1,032.3) |
| 5 | Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ | 1 | 1.0 | 13.5 | (12.5) | (0.0) | (12.5) |
| 6 | Баян өсөх агро ОНӨААТҮГ | 1 | 147.7 | 0.2 | 147.5 | 0.0 | 147.5 |
| 7 | Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв | 1 | 320.0 | 315.2 | 4.8 | 27.2 | 32.0 |
| | **ДҮН** | **7** | **16,610.6** | **16,091.2** | **519.4** | **(1,574.6)** | **(1,055.1)** |

**Эх сурвалж:** *Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.10. Нэмэлт санхүүжилтийн данс

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 5 байгууллага 61.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас 39 байгууллага 989.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 22 байгууллага 1,560.4 сая, нийт 2,612.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 47 байгууллага 2,263.8 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 1 байгууллага 120.0 сая, хөрөнгийн зардалд 3 байгууллага 10.1 сая нийт 2,393.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 218.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа ахлан аудитор Ж.Өсөхбаяр нар гүйцэтгэж хяналтыг аудитын менежер А.Цээням, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1а/210 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 91,031.4 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 455.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 295.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол УИХ-аас төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж мөрдүүлсэн байна.

Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолоор дараах арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосон байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;
2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.

Баянхонгор аймгийн 2022 оны төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 9/24 дүгээр тогтоолоор 2,406.2 сая төгрөгөөр бууруулж 35,221.5 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Дээрх төсвийн тодотголтой холбоотой зарим онцлог арга хэмжээг сумын төвшинд хэрэгжүүлэх, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор сумдын 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжийг сумдад хүргүүлсэн байна.

Үүний үр дүнд Баянхонгор аймгийн сумдын ИТХ-аас сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчдын төсөвт тодотгол хийж төсвийн нийт зардлыг 2,080.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

**Хүснэгт 1.** Төсөвт хийсэн тодотголын нэгтгэл /сая төгрөгөөр/

| Сумын нэр | Анх баталсан | Тодотгосон | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Баацагаан | 1,586.5 | 1,519.4 | 67.1 |
| Баянбулаг | 1,242.2 | 1,206.4 | 35.8 |
| Баянговь | 1,752.3 | 1,628.2 | 124.0 |
| Баянлиг | 1,889.0 | 1,942.9 | (53.9) |
| Баян-Овоо | 2,359.3 | 2,065.9 | 293.4 |
| Баян-Өндөр | 1,618.2 | 1,615.6 | 2.6 |
| Баянхонгор | 10,709.9 | 9,552.9 | 1,157.0 |
| Баянцагаан | 1,790.3 | 1,719.7 | 70.5 |
| Богд | 1,347.9 | 1,288.0 | 59.9 |
| Бөмбөгөр | 1,327.9 | 1,465.8 | (137.9) |
| Бууцагаан | 1,957.4 | 1,817.8 | 139.6 |
| Галуут | 1,817.8 | 1,711.2 | 106.6 |
| Гурванбулаг | 1,333.5 | 1,346.8 | (13.3) |
| Жаргалант | 1,531.1 | 1,465.9 | 65.2 |
| Жинст | 1,318.4 | 1,210.4 | 108.0 |
| Заг | 1,214.0 | 1,161.0 | 53.0 |
| Өлзийт | 1,789.0 | 1,802.0 | (13.0) |
| Хүрээмарал | 1,236.4 | 1,264.6 | (28.2) |
| Шинэжинст | 1,668.8 | 1,700.7 | (31.8) |
| Эрдэнэцогт | 1,329.3 | 1,253.9 | 75.4 |
| **Дүн** | **40,819.2** | **38,739.2** | **2,080.0** |

**Эх сурвалж:** Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Баянхонгор сумын ИТХ-аар сумын Засаг даргын 2022 онд төсвийн зардлын хэмжээг 1,157.0 сая төгрөгөөр нийт зардлыг бууруулан баталж, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 328.8 сая төгрөгийг хасаж гүйцэтгэлээр 713.6 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн, Баян-Овоо сумын ИТХ-аар сумын Засаг даргын 2022 оны төсвийн зардлыг 293.4 сая төгрөгөөр бууруулж аймгийн төсөвт 241.4 сая төгрөг төвлөрүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

### Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 216.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 21.0 сая төгрөгийн зөрчилд 26 төлбөрийн акт тогтоож, 56.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 17 албан шаардлага өгч, 143,6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 14 зөвлөмж хүргүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах албан

шаардлага өгч, орон нутгийн өмчит хуулийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоож Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв. Үүнд

1. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022.12.23-ны өдрийн 95/280 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталж бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мөрдөж ажиллахыг үүрэг болгосон байна.

   Дээрх тушаалд үндэслэн аймгийн Засаг даргын 2023.02.17-ны өдрийн “Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжилтийг хангах тухай” А/103 дугаар захирамжаар “Орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээд тээврийн хэрэгслийг ашиглаж, эзэмших журам”, “Албан тушаалын, албан ажлын суудлын автомашины тоо, төрөл, автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг баталж журмаар зөвшөөрөгдөөгүй нийт 78 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосон байна.

   Энэ нь Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын 2 дахь “Энэ тогтоолын 1-д заасны дагуу татан төвлөрүүлсэн төрийн өмчид бүртгэлтэй суудлын автомашиныг "Засгийн газрын авто бааз" УТҮГ-т, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг тухайн аймаг, нийслэлийн харьяа авто тээврийн байгууллагад шилжүүлж, төрийн болон орон нутгийн байгууллагын нийтлэг үйлчилгээний хүрээнд дуудлагын автомашины зориулалтаар ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай” гэсэн заалттай нийцэхгүй байна.

   Тус захирамжийн дагуу төсөвт байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглаж байсан 44 автомашиныг аймгийн Орон нутгийн өмчийн газарт татан төвлөрүүлж аймгийн Засаг даргын 2023.03.20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 20 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 6 автомашиныг акталж, 10 автомашиныг автомашин дутагдалтай төсөвт байгууллагуудад балансаас балансt шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

   Харин 28 байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 34 тээврийн хэрэгслийг Орон нутгийн өмчийн газарт 2023.03.25-ны өдрийн байдлаар ирүүлээгүй байна.

   Иймд тус автомашинуудыг татан төвлөрүүлж Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн өмчит 8 аж ахуйн нэгж байгаа тус аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх удирдлагын цалин хөлсийг аймгийн ИТХ-аас тогтоогоогүй ба 5 аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын цалинг Төлөөлөн удирдах зөвлөл, 3 аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын цалинг аймгийн Засаг даргын захирамжаар тогтоосон байна.

   Мөн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аас тогтоож мөрдүүлээгүй байна.

   Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг зөрчиж байгаа тул орон нутгийн өмчит хуулийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 4.4 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 84 мэдээллийг хугацаанд нь, 57 мэдээллийг хугацаа хоцроож, 13 мэдээллийг мэдээлээгүй байна.

*Хүснэгт 22. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | хугацаа | төрөл | удаа | хугацаанд нь мэдээлсэн | хугацаа хоцроосон | Мэдээлээгүй | Хоцроосон мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 13 | 13 | 8 | 1 | 2 | ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт тус тус мэдээлээгүй. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн |
| 2 | Хагас жил | 3 | 3 | 1 | 2 | | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл |
| 3 | Улирал бүр | 2 | 8 | 4 | 3 | 1 | ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 4 улирал мэдээлээгүй, 3 улирал хугацаа хоцроосон Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2.3 дугаар улирал |
| 4 | Сар бүр | 5 | 60 | 23 | 36 | 1 | ОНХС-ийн төлөвлөгөө,гүйцэтгэл 1,2,3,4,5,6,7,8,9,10 саруудад, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 2,9 сарууд хугацаа хоцроосон 12 сар мэдээлээгүй, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 1,5,6,7,9-р сарууддад, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 1-9 саруудад, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 1-9 сар, 11 саруудад, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 1-9 саруудад |
| 5 | Тухай бүр | 6 | 72 | 48 | 15 | 9 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 1-4, 6-9, 12 саруудад мэдээлээгүй, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 1-9, сарууддад, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 2-р сар, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 1, 6-8 сарууддад хугацаа хоцроосон |
| **НИЙТ** | | **29** | **156** | **84** | **57** | **13** | |

*Эх сурвалж. Баянхонгор аймгийн шилэн дансны цахим хуудас*

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах орон нутгийн өмчит 114 төсөвт байгууллага, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авч байгаа, 4 өрхийн эмнэлэг, ахмадын хороо, нийт 124 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулж иржээ.

## 4.5 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 49 төсвийн байгууллага, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 123 байгууллагын санхүүгийн тайлан болон ангилагдаагүй зардал, замын сан, хяналтын барьцаа данс, засаг даргын нөөц хөрөнгийн данс нийт 5 дансны гүйлгээ нэгтгэгдсэнээс 123 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж 33 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 90 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2022 оны 01/06 дугаар тогтоолоор “Байшинтын таг” ОНӨААТҮГ-ыг, Шинэжинст сумын Засаг даргын 2022 оны А/82 дугаар захирамжаар Шинэжинст сумын “Тохижилт үйлчилгээний алба” ОНӨТҮГ-ыг тус тус татан буулгасныг хаалтын баланс гаргаж хааж аймгийн ИТХ-ын 2021 оны 3/7 дугаар тогтоолоор “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-ыг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 152 дугаар тогтоолоор “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ыг тус тус үүсгэн байгуулж санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 90 байгууллагыг түүвэрт хамруулж, 33 байгууллагад дүгнэлт хүргүүлснээс 25 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 8 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,456.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 613.2 сая төгрөгийн 34 алдааг санхүүгийн тайланд залруулж, 258.0 сая төгрөгийн зөрчилд 64 төлбөрийн акт тогтоож, 1,553.0 сая төгрөгийн зөрчилд 82 албан шаардлага хүргүүлж, 2,787.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй 164 зөвлөмжийг хүргүүлж, 244.8 сая төгрөгийн зөрчил гаргасан 8 албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг томилсон эрх бүхий этгээдэд хүргүүлсэн.

Нийт алдаа, зөрчлийн 80.8 хувь буюу 4,406.0 сая төгрөг нь санхүүгийн тайлагналын алдаа зөрчил байгаа бол 19.2 хувь буюу 1,050.0 сая төгрөгийн алдаа, зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын алдаа, зөрчил байна.

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулбал нийт алдааны дүн 8,444.6 сая төгрөгөөр буурсан байгаа нь төсвийн шинэчлэлтэй холбоотой 116 төсвийн байгууллага харьяа яамдын санхүүгийн нэгтгэсэн тайлан нэгтгэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 25. Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл /сая.төг/*

| Он | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Залруулагдаагүй алдааны дүн | Залруулсан алдааны дүн | Нийт алдааны дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 2020 | 381.6 | 2,391.4 | 8,559.7 | 11,332.7 | 1,083.1 | 12,415.8 |
| 2021 | 258.0 | 1,797.8 | 2,787.1 | 4,842.8 | 613.2 | 5,456.0 |
| **Өөрчлөлт** | **(123.6)** | **(593.6)** | **(5,772.7)** | **(6,489.9)** | **(469.9)** | **(6,959.8)** |

*<u>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:</u>*

Харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн байгууллагаас 14 байгууллагад “Зөрчилгүй”, Баянцагаан, Богд, Жаргалант, Баян-Өндөр, Бөмбөгөр, Баян-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

*Хүснэгт 26. “Хязгаарлалттай”, “Сөрөг” санал дүгнэлт авсан төсвийн төвлөрүүлэн захирагч*

| БАЙГУУЛЛАГЫН НЭР | ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ |
|---|---|
| **"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"** | |
| **БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА** | -Сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн материаллаг алдааны дүн нь 37,282.5 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг түвшнээс хэтэрсэн;<br>-Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос газрын төлбөр 1627.9 мянга, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 18,525.1 мянга, малын тоо толгойн албан татварын орлого 41,599.9 мянган төгрөгөөр тасарсан. |
| **БОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА** | -Сумын төсөвт байгууллагууд, төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2-д заасан цаглаварт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй;<br>-Санхүүгийн тайланд төрийн сангийн дансны орлого, зарлагын гүйлгээг ЗДТГ 63,874.8 мянга, ИТХ 3,437.1 мянга, нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээг ИТХ 3,574.1 мянга, ЗДТГ 1,957.2 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг тус тус дутуу тусгасан, ЗДТГ нь 2022 оны 10-12 сарын 81,626.4 мянган төгрөгийн цалин НДШ-ийн зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, 10-12 дугаар сарын нярвын тайланг ирүүлээгүй, 2022 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй; Орон нутгийн хөгжлийн сангаас иргэдээс санал аваагүй төсөл арга хэмжээнд болон зориулалт бусаар 11,968.5 мянган төгрөгийг зарцуулсан;<br>-Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 222,998.6 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй сумын ИТХ нь эзэмшигч тогтоогоогүй. |
| **ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА** | -Сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн материаллаг алдааны дүн нь 37,282.5 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг түвшнээс хэтэрсэн; |

| БАЙГУУЛЛАГЫН НЭР | ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ |
|---|---|
| | -Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлээгүйгээс Сум хөгжүүлэх сангаас зээл авсан зээлдэгч нарын зээлийн үлдэгдэл, зээлийн эргэн төлөлтийг зөрүүтэй тооцсон, өмнөх оны алдааг нягтлан бодогч давтан гаргасан, тайланг буруу илэрхийлсэн. |
| **БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА** | Засаг даргын Тамгын газар, Сум хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн материаллаг алдааны дүн нь 48,580.2 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг түвшнээс хэтэрсэн. |
| **БӨМБӨГӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА** | -Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн материаллаг алдааны дүн нь 92,127.6 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг түвшнээс хэтэрсэн;<br>-Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. |
| **БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА** | -Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 90,843.3 мянган төгрөг төвлөрсөн байхад орон нутгийн хөгжлийн санд 107,000.0 мянган төгрөг буюу орон нутгийн орлогоос 16,156.7 мянган төгрөг илүү хуваарилсан;<br>-Тус сумын сум хөгжүүлэх сангаас зээл авсан 10 зээлдэгчийн 58090.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ч хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй;<br>-Баян-Овоо сумын "Байгалийн музей болон орон нутаг судлах танхимын барилга"-ын 298,420.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгүүлэхдээ сумын Засаг дарга нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй "Гэгээн шавь" ХХК-тай шууд гэрээ байгуулан байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 150,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон;<br>-Тус сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс тайлант онд нийт 65945.0 мянган төгрөгийг зарцуулсан ч зарцуулалтын тайлан, захирамжийн хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлд тайлагнаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ. |

*Эх сурвалж: Төсвийн төвлөрүүлэн захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ*

Аудитаар нийт 1,828.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 162.7 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 77.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 366.2 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага хүргүүлж, 977.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 48 зөвлөмж өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн тайланд илэрсэн нийтлэг зөрчил нь төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд нийцүүлэн бэлтгээгүй, сумдын орон нутгийн орлогын гүйцэтгэлийн аймгийн Татварын хэлтэст үнэн зөв мэдээлээгүй, Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг буруу оруулсантай холбоотой тул цаашид сумдын санхүүгийн албаны дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

*<u>Төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:</u>*

Харьяа төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сангийн 91 тайланд аудит хийснээс 84 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 7 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 5 байгууллагад “Зөрчилгүй”, 2 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,457.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 396.3 сая төгрөгийн 28 алдааг залруулж, 153.6 сая төгрөгийн зөрчилд 51 төлбөрийн акт тогтоож, 1,143.6 сая төгрөгийн зөрчилд 53 албан шаардлага хүргүүлж, 1,763.8 сая төгрөгийн зөрчилд 100 зөвлөмж өглөө.

*Хүснэгт 27. “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан төсвийн шууд захирагч*

| БАЙГУУЛЛАГЫН НЭР | ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ |
|---|---|
| **"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"** | |
| **БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИ** | -Тайлант онд 3,153.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 14,479.0 мянган төгрөгийн мод, 12,622.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг акталж устгахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаагүй, устгал хийсэн актыг үйлдээгүй;<br>-Санхүүгийн тайланд өөрийн орлогыг 8,610.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан;<br>-Санхүүгийн тайланд 594,846.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байхад жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 593,378.5 мянган төгрөгийн хөрөнгө тоологдож, 1,467.5 мянган төгрөгөөр зөрүүтэй, тооллогын комисс үндсэн хөрөнгө, бараа материалыг нэр төрлөөр нь тоолоогүй, нягтлан бодогч тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй;<br>-Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,370.0 мянга, хандив тусламжаар ирсэн 44,520.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд зөв бүртгээгүй; |

| БАЙГУУЛЛАГЫН НЭР | ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ |
|---|---|
| | -Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах албан шаардлага, бараа материалыг акталж устгахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаж, устгал хийсэн акт үйлдэж, анхан шатны баримтад хавсаргах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй; |
